



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 1/46

Жаргалтхаан сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аркал Эрдэнэ ХХК (6155693) нь Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А-271 дугаар тушаалаар авсан үржлийн адуу импортлох тусгай зөвшөөрөл, ОХУ-ын иргэн Доржиев Радислав Васильевичтэй хийсэн худалдах, худалдан авах 386 дугаарт гэрээг үндэслэн Алтанбулаг боомтоор импортоор 4 толгой үржлийн адууг нэвтрүүлэх тул Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр, Төвийн, Нуур 101 тоот хаягт улсын хилээр орж ирсэн өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэмд оруулсугай.

2. Хорио цээрийн дэглэмийн хугацаанд тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгсэл, адууны зүчээ, хашаа хороонд халдваргүйтгэл хийх, импортоор орж ирсэн адуунаас зааврын дагуу дээж авч мал эмнэлгийн итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээнд хамруулж, холбогдох мэдээ тайланг нэгтгэн танилцуулахыг Мөнхбадрах Зоргол ХХК мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Б.Уранцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлагагүй хандсан албан хаагч, иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ тооцон ажиллахыг сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (П.Батдулам)-д даалгасугай.

ДАРГА

С.ГАНБАТ



Data (D:)/A4 zahiramj

232501127